

ДЭЛХИЙН II ДАЙН БА БНМАУ

Ж.Баясах¹
Ж.Орхон²

Товч агуулга: Дэлхийн II дайн 1939-1945 онуудад үргэлжилсэн ба энэхүү дайн нь дэлхий дахины томоохон зөрчил байсан бөгөөд хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн аймшигт дайн байсан билээ. Дэлхийн агуу хүчнүүдийг хуримтлуулсан энэ дайнд улс орнууд хоёр хэсэгт хуваагдсан нь Холбоотнууд болон Тэнхлэгийнхэн байлаа. Энэхүү дайнд 61 улс орон, дэлхийн хүн амын 80 шахам хувь оролцож, 110 сая гаруй хүн цэргийн албанд татагдаж нийт 60 сая хүн амь үрэгдэв. Монголчууд тус дайнд биеэр оролцоогүй ч эд материал, сэтгэл санааны асар их дэм, тусламжийг Зөвлөлтийн ард түмэнд үзүүлж 1936 онд байгуулсан “харилцан тусалцах протокол” дахь үүргээ биелүүлсэн.

Түлхүүр үгс: зөвлөлтийн ард түмэн, холбоотон, германы фашистууд, бэлэглэлийн комисс, танкийн цуваа, онгоцны эскадриль, Ялтын хурал, статус-кво, де-юре, жийргэвч улс, тусгаар тогтнол

Key words: soviet people, confederate, german fascists, commission, tank`s column, airplane`s escadrille, Yalta conference, status-quo, de-jure, buffer, independence

Өмнөтгөл

Хүн төрөлхтөний түүхэнд дэлхий нийтийг хамарсан хамгийн том, хамгийн их хор хөнөөл учруулж, хамгийн олон улс, үндэстэн оролцсон, шийдсэн асуудлаараа томоохон байр эзэлдэг үйл явдал бол Дэлхийн II дайн мөн. Энэ дайны эхлэл, өрнөлийг олон үйл явдал, байлдаан зэргээр тодорхойлох нь бий. Монголын дорнод хил дээр 1939

1. ШУА-ийн Олон Улсын харилцааны хүрээлэнгийн захирал, Түүхийн шинжлэх ухааны доктор /Sc.D/, проф bayasakhjk@yahoo.com

2 ШУА-ийн Олон Улсын харилцааны хүрээлэнгийн ЭША, магистр jamsran1945@yahoo.com

онд болсон “Халх голын” дайн ч хоёрдугаар дайны Ази дахь эхлэл байсан гэж үзэх болсон. Гэхдээ дайны цөм хэсэг нь Зөвлөлтийн улаан арми, Германы нацистуудын хооронд өрнөснийг нийтээрээ хүлээн зөвшөөрдөг бөгөөд уг дайныг 1941 оны 6 дугаар сарын 22-ноос 1945 оны 5 дугаар сарын 9-нөөр “хайрцагладаг”.

1939 онд Халхын голд Монгол, Оросын хамтарсан цэргүүд Японы Квантуны армийн VI дивизийг бут цохисон. Энэхүү ялалтын 75 жилийн ойг 2014 онд өндөр дээд хэмжээнд Монгол, ОХУ хамтран тэмдэглэсэн билээ. 2014 оны 9 дүгээр сард манай улсад ажлын айлчлал хийсэн ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинд хандан Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлсэн үгэндээ “Одоогоос 75 жилийн тэртээд Монголын дорнод хил хязгаар нутаг Халхын голд болсон байлдаан нь айсуу дэлхийн дайны угтал болсон билээ. Халхын голын тулалдааны үйл явц улирах он цагийн эрхээр энэхүү түүхт ялалтын ач холбогдол улам бүр тодорсоор байх болно. Энэ ялалт Монгол Улсын төрийн тусгаар тогтнолыг улам бэхжүүлж, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататган хамгаалж, Монгол-Оросын ард түмний найрамдлыг дайчин нөхөрлөлөөр гагнасан юм. Энэ ялалт Зөвлөлтийн Алс Дорнодод дайны аюулыг хазаарлан зогсоож, нэгэн зэрэг хоёр фронт дээр тулалдахаас сэргийлж чадсан нь маргашгүй түүхэн үнэн билээ”³ хэмээн энэхүү ялалтын ач холбогдлыг дүгнэсэн юм.

Дайны үед БНМАУ-аас ЗСБНХУ-д үзүүлсэн тусламж

1941 оны 6 дугаар сарын 22-нд ЗСБНХУ руу Германы фашистууд дайрч дэлхийн II дайн эхэлсэн өдөр БНМАУ-ын Намын төв хорооны 32, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 40, сайд нарын зөвлөлийн 30 дугаар хуралдаануудыг нэгтгэн, өргөтгөсөн бүрэлдэхүүнээр яаравчлан хуралдуулж гол асуудал болох дайны асуудлыг хэлэлцэв. Уг хурлаас гаргасан 1 тоот тогтоолд “Манай эрх чөлөөт тусгаар тогтносон орны бүх иргэд нь... Германы фашист нарын зүгээс урвасан хулгайн үйлсийг үзүүлсэн явдлыг туйлын жигшүүртэй үзэх ба түүний хариуд холбоот улстай эв найрамдлыг улам гүнзгийрүүлэх...”-ээр заасан нь чухамдаа дайны асуудлаарх БНМАУ-ын байр суурийг тодорхойлон, улс орныг дайны байдалд шилжүүлсэн хэрэг байв. Түүнчлэн «Зөвлөлтийн ард түмэнтэй эвдэршгүй бат найрамдалтай манай эрх чөлөөг эрхэмлэгч,

3. В.Путинд зориулсан хүндэтгэлийн зоог дээр Ц.Элбэгдоржийн хэлсэн үг, 2014 оны 9-р сарын 4. 18:23

тусгаар тогтносон улсын бүх ард түмэн фашистын Герман ийнхүү итгэл эвдэн халдсаныг туйлаас буруушааж, зөвлөлт, монголын ард түмний найрамдлыг бүх талаар бэхжүүлэн, БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1936 оны 3 дугаар сарын 12-нд байгуулсан харилцан туслах тухай гэрээгээр хүлээсэн үүрэгтээ үнэнч байх болно»⁴ хэмээн мэдэгджээ.

“Бүхнийг улаан армид, бүхнийг фашизмыг ялахын төлөө” уриан дор эх орны үйлдвэрлэлийг цэрэг дайны бүтээгдэхүүн үйлдвэрлэх горимд шилжүүлэн, агт морьд, алт мөнгө, хүнс мах, хувцас хэрэглэл, арьс нэхий зэргийг ихээр бэлтгэн фронтод хүргэх аян ид өрнөж эхлэв. Ард түмний бэлгийг хүлээн авах, хүргүүлэх үүрэг бүхий Засгийн газрын Бэлэглэлийн комиссыг 1941 оны 9 дүгээр сард байгуулав. Тус комисс дайны жилүүдэд нийтдээ 8 удаа фронтод бэлэг хүргэж өгсөн байна. Дээрх комисс 1944 оны 4 дүгээр сард тавьсан илтгэлдээ энэ хугацаанд 4 удаа нийт 8 цуваа бэлэг, бэлэн мөнгөөр 24 895 311/ хорин дөрвөн сая найман зуун ерэн таван мянга гурван зуун арван нэгэн/ төгрөг 58 мөнгө бүхий эд зүйлийн тусламж цуглуулсан хэмээн тайлагнажээ. Багцаагаар нийт кампанит ажлаар 980 вагон хүнсний зүйл, мах, эсгий эдлэл, нэхий дээл зэрэг хувцас хэрэгсэл бэлэглэсэн нь тухайн үеийн ханшаар 78 сая рублийн үнэ хүрэхүйц дүн байлаа.⁵

Хамгийн тодорхой мэдээлэгдэж үлдсэн бэлэглэл бол 1942 оны 11 дүгээр сард явуулсан хоёр дахь удаагийн хүргэлт юм. Учир нь энэ онд Октябрийн хувьсгалын 25 жилийн ой тохиосон бөгөөд нийт 236 вагоноос бүрдсэн галт тэрэгний дөрвөн цуваа бэлэг аваачжээ. Фронтод бэлэг илгээх явдлыг үзэл суртлын томоохон арга хэмжээ болгож өрнүүлсний дотор энэ үйл хэрэгт манлайлан оролцсон хүмүүсийг ард түмний төлөөлөл болгон бэлэг хүргэж өгөх комиссын бүрэлдэхүүнд оролцуулж байлаа.

1942 оны 3 дугаар сард БНМАУ-ын Засгийн газар зөвлөлтийн армид зориулсан агт морьдыг малчин ардуудаас улсаас жич тогтоосон үнээр худалдаж авах тогтоол гаргав. Дайны турш Монголоос ЗСБНХУ-д 500 мянга гаруй агт морь нийлүүлсэн нь манай улсын бүх адууны 10 хувь байв. Дайны хүнд бэрх замыг монгол мориор туулж Берлин

4. БНМАУ, Зөвлөлт эх орны дайны үед. Баримт бичгийн эмхэтгэл. (Эмхэтгэсэн Н.Сэр-Оджав). УБ., 1954, х.6.

5. “Монгол түмний ариун дайн”, Д.Энхболдбаатар, “Үндэсний тойм” сэтгүүд, 2011-05-09.

хүрсэн дайчид монгол морь маш тэвчээртэй, тордлого шаарддаггүйг тэмдэглэж байсныг түүхэн баримтуудад тэмдэглэсэн байдаг.

Түүнчлэн БНМАУ-ын Засгийн газар танкийн дивиз байгуулахад хөрөнгө хуримтлуулах шийдвэрийг 1942 оны 1 дүгээр сарын 16-нд гаргажээ. Бага хурлын чуулганаас монголын нийт ард түмний хүсэл зоригийг илэрхийлэн:

1. Хувьсгалт Монголын нэрэмжит танкийн цуваа худалдаж авч, Зөвлөлт Холбоот Улсын алдарт Улаан армид бэлэглэх,

2. Энэхүү шийдвэрийг тайлбарлан таниулах талаар малчин ард, ажилчин, албан хаагчдын дунд олныг хамарсан зохих ажил хийж, Хувьсгалт Монголын нэрэмжит танкийн цуваа худалдаж авах хөрөнгө хуримтлуулах ажил зохион байгуулахыг засгийн газарт даалгахаар тогтоожээ.

Ийнхүү “Хувьсгалт Монгол” танкийн бригад, “Монгол ард улс” нисэх эскадриль байгуулсан нь дайны түүхэнд чухал байр эзэлдэг. “Хувьсгалт Монгол” танкийн цувааг БНМАУ-ын нийт иргэдийн сайн дураараа хандивлаж, ЗХУ-ын “Внешторгбанк” банкинд хуримтлуулсан хөрөнгөөр босгосон юм. 1942 оны 2 дугаар сарын 10-нд тус банкинд Монголын ард түмний хандивласан тухайн үеийн ханшаар 2,5 сая төгрөг, 100 мянган ам. доллар, 300 кг алт төвлөрсөн нь тухайн үеийн зөвлөлтийн 3 815 725 /гурван сая найман зуун арван таван мянга долоон зуун хорин таван/ рубль болжээ.⁶

Маршал Х.Чойбалсан тэргүүтэй Монголын төлөөлөгчид 1943 оны 1 дүгээр сарын 12-нд ЗСБНХУ-д биечлэн ирж, Т-34 танк 32ширхэг, Т-70 танк 21 ширхэгийг тус тус зөвлөлтийн дайчдад гардуулан өгч, Улаан армийн улаан тугийн одонт 112 дугаар бригадад «Хувьсгалт Монгол» гэсэн хүндэт нэр олгов. Танкуудын цамхаг дээр “Хувьсгалт Монгол” буюу “Революционная Монголия” бичгээс гадна чухам хэний хөрөнгөөр боссоныг тодорхой бичсэн байв.

Мөн 1943 онд БНМАУ-ын Бага хурал, Засгийн газрын шийдвэрээр нисэх онгоцны «Монгол ард» эскадрилийг худалдаж авах хөрөнгө хуримтлуулах ажил зохион байгуулав. 1943 оны 7 дугаар сард

6. “Эх орны дайнд Монгол улсын оролцоо, түүхэн баримтууд”, Д.Моломжамц, Оюутны хөгжил клуб, 2010-05-02.

ЗСБНХУ-ын Сангийн ардын комиссариатын дансанд хоёр сая төгрөг гуйвуулжээ. 1943 оны 8 дугаар сарын 18-нд И.Сталин Улаан армийн дайчдад дорвитой тусламж үзүүлж байгаад нь БНМАУ-ын Засгийн газар болон маршал Чойбалсанд талархал илэрхийлсэн байна.

1943 оны 9 дүгээр сарын 25-нд Смоленск мужийн Вязовая өртөөний хээрийн нисэх буудалд сөнөөгч нисэх онгоцны 322 дугаар дивизийн гвардийн хоёрдугаар хороонд «Монгол ард» эскадрилийг хүлээлгэн өгөх ёслол болов. Танкийн «Хувьсгалт Монгол» бригад, байлдааны нисэх онгоцны «Монгол ард» эскадриль гитлерчүүдтэй хийсэн олон тулалдаанд оролцож, дайныг Берлинд дуусгасан юм.⁷

Мөн танкнуудын зэрэгцээ монголчууд Улаан армид нийт 1000 тонн мах, 90 тонн тос масло, 80 тонн хиаман бүтээгдэхүүн, 150 тонн хүнсний бүтээгдэхүүн, 30000 нэхий дээл, 30000 хос эсгий гутал, 30000 нэхий хантааз зэрэг 237 вагон ачаа бараа бэлэглэсэн байдаг.⁸

Түүнчлэн БНМАУ зэвсэгт хүчнээ бэхжүүлэх нь тусламжийн өөр нэг чиглэл байв. Цэргийн тоо байнга нэмэгдэж, дайны эцэс гэхэд гурав дахин нэмэгдэж, манай улсын төсвийн зарлагын 48,5% армид зарцуулагдаж байлаа. Тухайн үед манай зэвсэгт хүчнийг Квантуны армийг тогтоон барих нэмэлт хүчин зүйл гэж үзэж байв.

Дайны жилүүдэд хоёр улсын хоорондын худалдаа зогсоогүй бөгөөд Монголоос ЗХУ-д жил бүр дунджаар 140 мянга гаруй үхэр, 1 сая шахам хонь, ямаа, 170 мянган ширхэг үхрийн арьс шир, их хэмжээний гянт болд нийлүүлж, оронд нь бензин, шатахуун, гурил, цай, даавуу, хувцас зэргийг авч байв. Харин БНМАУ-ын Засгийн газар дайны жилүүдэд ЗСБНХУ-аас бараа импортлохоо эрс багасгаж, хөнгөн үйлдвэрийн зарим төрлийн барааг өөрсдөө үйлдвэрлэж байв.⁹ Ийнхүү БНМАУ Дэлхийн II дайны үеэр ЗХУ-ын Ази дахь цорын ганц холбоотон байсан төдийгүй оросын ард түмэнд сэтгэл санааны болон эд материалын ихээхэн тусламж дэмжлэг үзүүлснээр аугаа их ялалтыг ойртуулахад гар бие оролцсон нь маргашгүй үнэн.

7. Дэлхийн 2 р дайнд Монгол улс оролцсон нь. 2009 оны 10-р сарын 12, www.gogo.mn

8. Инфографик: Дэлхийн II дайнд Монголын оролцоо. Баатарцогт Сувд-Эрдэнэ. www.itoim.mn/

9. “Дэлхийн хоёрдугаар дайны үед Монгол Улсаас Зөвлөлт Холбоот Улсад үзүүлсэн тусламж” А.Ариунзаяа, Монголын Үндэсний олон нийтийн цахим хуудас.

БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн нь

Дэлхийн II дайны шувтаргаар фашист Герман Улс ялагдах нь тодорхой болсон үе буюу 1945 оны 2 дугаар сарын 4-нөөс 11-ний өдрүүдэд ЗХУ-ын Крымын Ялта хотноо ЗСБНХУ, АНУ, Их Британийн удирдагч нар оролцсон бага хурал дээр дайны дараа Европыг хэрхэн өөрчлөн байгуулах талаар хэлэлцээр эхэлсэн нь манай улсын тусгаар тогтнолтой зайлшгүй холбоотой үйл явдал байв. Энэ хурлаар хэд хэдэн чухал асуудал хэлэлцсэн, тухайлбал, Германыг буулгаж авах, дэлхийн II дайны дараахь Европын улс төр, эдийн засагт дээрх улсууд ямар байдлаар нөлөөгөө тогтоох тухай зэрэг асуудлууд байлаа. Мөн гурван сарын дараа Дэлхийн II дайныг бүрмөсөн дуусгахын тулд ЗХУ Японд дайн зарлах шийдвэр гаргасан юм. Түүнчлэн уг хурлаар ЗХУ-ын саналаар БНМАУ-ын статус квог хэлэлцээд хүлээн зөвшөөрсөн. Энэ үеэр холбоотнууд ЗХУ-ыг Японы эсрэг дайнд оролцох хүсэлтийг тавихад И.Сталин хэд хэдэн болзлыг сөргүүлэн тавьж, хамгийн эхэнд Монголын Тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх асуудлыг тавьсан байна. Тэрбээр байр сууриа илэрхийлэхдээ “Нэгэн улс Гадаад Монголыг ЗСБНХУ руу халдан түрэмгийлэх, түшиц газраа болгох гээд байна. Гадаад Монгол нь бүрэн тусгаар тогтнож, хэний ч дор орохыг хүсэхгүй байна”¹⁰ хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, БНМАУ-ын хил хязгаар, газар нутгийг байгаа чигээр нь тусгаар улс болгон хүлээн зөвшөөрөх шийдвэр гаргаж И.Сталины саналаар АНУ-ын Ерөнхийлөгч Ф.Рузвельт Хятадын Гоминьданы удирдагч Чан Кайшид БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх шаардлага тавих үүргийг хүлээсэн юм.

Мөн И.Сталин Өвөр Монголыг Гадаад Монголтой нэгтгэх нь Хятадын бүрэн бүтэн байдалд заналхийлэх аюултай хэмээн үзэж, харин хамгийн боломжийн хувилбар нь Гадаад Монголын статус-квог хадгалан үлдээх явдал бөгөөд “статус-кво” гэдэг нь БНМАУ-ын Тусгаар тогтнол юм хэмээн онцлон тэмдэглэсэн байна. Ийнхүү Монголыг тусгаар тогтносон жийргэвч улс болгох гэсэн ЗХУ-ын ашиг сонирхол, Монголын ард түмний тусгаар тогтнох гэсэн ашиг сонирхол нийцэж байсан учраас зорилгодоо хүрч чадсан юм.

10. “Дэлхийн II дугаар дайны сүүлээр Монгол Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн нь.” А.Ариунзаяа. www.nam.mn.

Ялтын Гэрээгээр Японы эсрэг дайнд ЗХУ оролцох гурван үндсэн нөхцөл болзлыг баталжээ. Үүнд: нэгдүгээрт, Гадаад Монголын (Бүгд Найрамдах Монгол Ард Улсын) статус-квог хэвээр хадгалах, хоёрдугаарт, Сахалины хойгийн өмнөд хэсэг болон Курилын арлуудыг ЗХУ-ын мэдэлд шилжүүлэх, гуравдугаарт, Хятадын дорнод төмөр зам болон Дайрен, Порт-Артур зэрэг боомтыг Орос улс урьд нь эзэмшилдээ байлгаж байсан байдлыг сэргээх зэрэг асуудлууд тусгагджээ.

Ялтын бага хурлаас хойш БНМАУ-ын олон улсын тавцанд де-юре хүлээн зөвшөөрөх эхлэл тавигдсан гэж болно. Энэ нь манай тусгаар тогтнолын хөгжлийн чухал түүхэн вйл явдал юм. Учир нь 1945 оны 10 дугаар сарын 20-нд Монгол орон даяар санал асуулга явуулж, монголын ард түмэн тусгаар тогтнолынхоо төлөө 100 хувь саналаа өгч, 1946 оны 1 дүгээр сарын 6-нд Чан Кайшигийн Засгийн газар БНМАУ-ыг хүлээн зөвшөөрч, улмаар мөн оны 2 дугаар сарын 10-нд Хятад Монголын хооронд дипломат харилцаа тогтоох болон дипломат төлөөлөгч харилцан суулгах тухай ноот бичгийг солилцжээ.

Ийнхүү Крымын Ялта хотноо болсон холбоотон их гүрнүүдийн тэргүүн нарын бага хурлаар Дэлхийн II дайны дараа улс орнуудын хувь заяаг хэрхэн яаж шийдвэрлэх асуудлыг хэлэлцэхийн зэрэгцээ БНМАУ-ын тусгаар тогтносон статус-квог хүлээн зөвшөөрсөн бөгөөд үүнд ЗХУ томоохон үүрэг гүйцэтгэсэн билээ. Ялта-Потсдамын бага хурлуудаар Дэлхийн II дайны дараах олон улсын дэг журамыг тогтоож, дэлхийн улс орон, ард түмний хувь заяаг өөрчлөн эргүүлсэн шийдвэрүүд гарсны нэг үр дүн бол яах аргагүй БНМАУ-ын Тусгаар тогтнолыг Их гүрнүүд, дараа нь Хятад Улс хүлээн зөвшөөрсөн явдал байв.

ДҮГНЭЛТ

Эцэст нь дүгнэн хэлэхэд, Монгол-Оросын түүхэн үндэстэй хамтын ажиллагаа биднийг хэдэн зууны турш нягт холбож ирсэн. Монгол Улс 1911, 1921 онд тусгаар тогтнолоо олж авахад Оросын төр, цэргийн дэмжлэг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. 1939 онд Монгол орны нутагт Халх голд халдсан японы милитаристуудын эсрэг монгол, зөвлөлтийн цэрэг хамтран байлдаж, 1945 онд Алс дорнодод чөлөөлөх дайнд оролцсон юм. Дэлхийн II дайны жилүүдэд Монгол Улс ЗСБНХУ-ын Ази дахь цорын ганц холбоотон байж, фашистын

Германтай тэмцэхэд эд материалын дорвитой тусламж үзүүлж, Японы эсрэг хамтран байлдаж байв. Дайны хүнд бэрх жилүүдэд зөвлөлтийн хүмүүс монголын ард түмний санаа сэтгэлийн төдийгүй, эд материалын дэмжлэгийг ямагт мэдэрч байлаа.

Монгол Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн нь Дэлхийн II дайны чухал үр дүн болсон нь маргашгүй түүхэн үнэн гэдэгтэй бүгд санал нийлэх буй. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2014 оны 9 дүгээр сард ажлын айлчлал хийх үеэр “дайны он жилүүд”-эд Монгол улс, монголчууд асар их тусламж үзүүлсэнийг онцгойлон дурьдаж онцолсон билээ.

НОМ ЗҮЙ

1. БНМАУ, Зөвлөлт эх орны дайны үед. Баримт бичгийн эмхэтгэл. (Эмхэтгэсэн Н.Сэр-Оджав). УБ., 1954, х.6.
2. “Монгол түмний ариун дайн”, Д.Энхболдбаатар, “Үндэсний тойм” сэтгүүл, 2011-05-09.
3. В.Путинд зориулсан хүндэтгэлийн зоог дээр Ц.Элбэгдоржийн хэлсэн үг, 2014 оны 9-р сарын 4. 18:23
4. “Эх орны дайнд Монгол улсын оролцоо, түүхэн баримтууд”, Д.Моломжамц, Оюутны хөгжил клуб, 2010-05-02.
5. “Дэлхийн 2 р дайнд Монгол улс оролцсон нь.” 2009 оны 10-р сарын 12, www.gogo.mn
6. Инфографик: “Дэлхийн II дайнд Монголын оролцоо.” Баатарцогт Сувд-Эрдэнэ.www.itoim.mn/
7. “Дэлхийн хоёрдугаар дайны үед Монгол Улсаас Зөвлөлт Холбоот Улсад үзүүлсэн тусламж” А.Ариунзаяа, Монголын Үндэсний олон нийтийн цахим хуудас.
8. “Дэлхийн II дугаар дайны сүүлээр Монгол Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн нь.” А.Ариунзаяа. www.nam.mn.
9. www.zasag.mn/news/2015.03.17 ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг ёсоор монголын ахмад дайчдыг одонгоор шагналаа.